

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН СОРИЛТУУД:

“Туравдагч хөри”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа,
хамтын ажиллагааг өргөжүүлэх нь

П.Баярцэцэг¹

***Abstract:** The main purpose of foreign policy of a country is to conduct foreign relations to the best possible advantage to serve its national interests. Democratic reforms and economic restructuring following the Soviet collapse provided the best ever opportunity for Mongolia to adopt its own “Multi-Pillar” foreign policy in 1994, thus safeguarding the country’s security and independent existence in the multi-polar world. The impact of foreign policy on the two geographic neighbours was that it articulated a new strategy to balance Mongolia’s relations with Russia and China that is known as the “third neighbour” policy. In other words, in a unipolar world, the multi-pillar policy or for that matter the ‘third neighbor’ policy should aim at ensuring security, both economic and strategic, by trying to overcome related challenges. So far Mongolia’s delicate balancing act has worked through the “third neighbor” approach which appears to be a viable but indeed a deft diplomacy.*

***Key words:** ‘Multi-pillar’ foreign policy, “third neighbor” policy, pragmatism, balanced relations, strategic partnership, comprehensive partnership, balance of influence.*

Монгол Улсын гадаад харилцааны шинэ орчин

XX зууны 90-ээд оны эхээр Монгол орны нийгэм, улс төрийн тогтолцоо эрс өөрчлөгдөж, шинээр бүрэлдэн тогтсон нийгэм-эдийн

1. БНХАУ, Жилиний Их Сургууль, Олон улсын харилцааны сургуулийн докторант;(P.Bayartsetseg 吉林大学公共外交学院国际关系学博士生)

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН СОРИЛТУУД

засгийн нөхцөл байдал олон улсын харилцаанд нээлттэй, илүү чөлөөтэй оролцох боломжийг нээж өгсөн юм. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын хоёр туйлт (Bipolar world) үеийнхээс эрс өөрчлөгдлөө. Хөгжлийн шинэ томоохон төвүүд тодорч, олон улсын харилцаанд тэдгээрийн үзүүлэх нөлөө өсөх хандлагатай болов. Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого, батлан хамгаалах салбарт хэрэгжүүлэх төрийн бодлогоо тодорхойлох үйл ажиллагаа дэлхий нийтэд төдийгүй Монгол улсад ч идэвхтэй хийгдэж байна. Энэ нь бодит байдал, өөрчлөгдсөн гадаад дотоод нөхцөлтэй шууд холбоотой юм.

Хүйтэн дайны дараах үед их гүрнүүдийн харилцаа, хүчний тэнцвэрт гүн гүнзгий өөрчлөлт гарч, АНУ ганцаар давамгайлсан нэг туйлт (Unipolar) тогтолцооноос олон туйлт (Multipolar) тогтолцоонд шилжих хандлага өнөөдрийн олон улсын дэг журмыг тодорхойлж байна. Манай хоёр хөршийн хүчний харьцаа, аюулгүй байдал, батлан хамгаалах болон гадаад бодлогод том өөрчлөлт мөн гарсаар байна. Эдгээр өөрчлөлт нь их гүрнүүдийн ашиг сонирхлын уулзварт орших Монгол улсын хувьд аюулгүй байдлын гадаад орчинд гарч буй хамгийн том суурь өөрчлөлт юм.

Сүүлийн хорь гаруй жилийн дотор Монгол улсын дотоод нөхцөл байдал, гадаад орчинд гарч байгаа өөрчлөлтийг тусгаж, төрийн бодлогын эрхэм зорилго, чиглэлийг тодорхойлох төрийн гол гол баримт бичгүүд шинэчлэгдсээр байна. Үүний дагуу Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (ҮАБҮБ), Гадаад бодлогын үзэл баримтлалыг 2010, 2011 онд Монгол улсын УИХ-ын чуулганаар хэлэлцэн баталсан билээ.

ҮАБ-ын Үзэл баримтлал бүхэлдээ хүний эрх, эрх чөлөө, эрх зүйт ёс, улс төрийн ардчилсан тогтолцоог хамгаас чухалчилж, эдгээр нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа хэмээн цохон тэмдэглэсэн байдаг. Мөн Үзэл баримтлалд: “Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг үндэсний аюулгүй байдал хэмээнэ гэж заасан бөгөөд Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын үйл ажиллагаа ба гадаад бодлого нь энхийг эрхэмлэсэн, нээлттэй, олон тулгуурт байна” гэдгийг онцолсон нь буй.

Монгол Улсын аюулгүй байдал нь гадаад орчны хүчин зүйл, түүний дотор их гүрнүүдийн хоорондох хүчний тэнцвэрээр тодорхойлогдож ирсэн түүхтэй. Өөрөөр хэлбэл, монголчуудын хүсэл зоригоос үл хамааран Монгол улсын аюулгүй байдлын бодлогод заавал харгалзах ёстой бодит нөхцөлүүд гэж бий. Эдгээр нөхцөл тус бүртгээ хувьсан өөрчлөгдөж байдаг боловч Хятад, Орос хэмээх хоёр гүрэн буюу манай хоёр мөнхийн хөршийн хоорондын харилцаа, хүчний тэнцвэр нь Монгол улсын оршин тогтнохуйн аюулгүй байдалтай шууд холбоотой хүчин зүйл болсоор ирсэн.

Мөн Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд *“Ази, Номхон далайн бүс нутаг, ялангуяа Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг хангах, энх тайвныг бэхжүүлэх, аюулгүй байдлын найдвартай тогтолцоог бий болгох бодлого явуулах”* гэж зааснаар дээрх асуудал дотооддоо шийдвэрлэгдсэн юм. Монгол нь Ази, Номхон далайн бүс нутагт орших улс бөгөөд улс төр, эдийн засаг аюулгүй байдлын хувьд Зүүн хойд Азийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болдог. Үүний зэрэгцээ Төв Ази дахь үйл явцаас хоцрохгүй байх чиг шугам тууштай баримтлах болов. Хөршүүдийнхээ талаар улс төрийн ялгавартай хандах сэтгэлгээнээс салж Монгол улс тэдгээртэй тэнцвэртэй харилцах зарчмыг тууштай баримталж байна. Энэхүү зарчим нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлсноор *“адил зай барьж, бүх асуудлаар адил байр суурьтай байхыг бус, харин хоёулантай нь итгэлцлийг бэхжүүлэх, сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх”*-ийг хэлж байгаа болно.

“Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал” (1994)-д олон улсын ерөнхий уур амьсгалыг *“Хэдийгээр дэлхийн улс гүрнүүд-эдийн засаг, технологийн хөгжлийн шаардлагаар ойртож, харилцан уялдаа холбоогоо бэхжүүлэх нөхцөл бүрэлдэж байгаа боловч улс орнуудын шашин, үндэстэн хоорондын зөрчил нэмэгдэж, үндсэрхэг үзэл газар авч, бүс нутгийн хэмжээнд болон тодорхой улс орны дотор зөрчил, мөргөлдөөн гарах магадлал багасахгүй байна. Эдүгээ хөрш хоёр оронд гарч буй томоохон өөрчлөлт нь Монгол улсын гадаад орчинд шууд нөлөөлж байна”* гэж үнэлэн дүгнэсэн.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН СОРИЛТУУД

1992 оны 1 дүгээр сарын 13-нд батлагдсан Монгол улсын ардчилсан шинэ “Үндсэн хууль”-ийн 10 дугаар зүйлийн нэгд тус улсын гадаад бодлогын үндсийг “Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна” хэмээн тодорхойлжээ.

Хүйтэн дайн дууссанаар Монголын геополитикийн орчин үндсээрээ өөрчлөгдөж, далайд гарцгүй (*land-locked*), цөмийн зэвсгээр хүрээлэгдсэн (*nu-clear-locked*), хоёр их гүрний дунд хашигдсан (*power-locked*) шинэ нөхцөл байдал буй болов. Геополитикийн шинэ орчинд Монгол улс үндэсний язгуур эрх ашгийг дээдэлсэн, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, бие даасан, нээлттэй гадаад бодлого явуулах болсон нь ХХ зууны эцэст Монгол улсын гадаад харилцаанд гарсан хамгийн том ололт байв.²

1994 онд батлагдсан Монгол улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд “гуравдагч хөрш” хийгээд “гуравдагч хөрш”-ийн бодлого, түншлэлийн талаар тусгайлан заагаагүй боловч “Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д анх удаа “Европын Холбоотой иж бүрэн түншлэлийн түвшинд харилцах бодлого баримтлана”, 2010 онд шинэчлэн батлагдсан “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “*Гуравдагч хөрш*”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй, ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ”,³ харин 2011 онд шинэчлэн батлагдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”⁴-ын 14.1.-д ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай

2. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ., 2014, тал 9.

3. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010

4. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал (2011.11.10-ны УИХ-ын 10 дугаар тогтоол). Гадаад бодлогын шинэчлэн найруулсан үзэл баримтлал. УИХ 2011 оны II сарын 10-ны өдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэн баталсан. Тус үзэл баримтлалыг 1994 онд Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлалыг баталснаас хойшхи хугацаанд манай улсын гадаад орчин, дотоод байдалд гарсан өөрчлөлтүүдийг харгалзан үзэж шинэчлэн найруулжээ. Шинэчлэн найруулсан үзэл баримтлал нь 1994 онд баталсан Гадаад бодлогын үзэл баримтлалын үндсийг ерөнхийд нь хадгалж, сүүлийн 16 жилд дэлхийн улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, байгаль орчны зэрэг салбарт гарсан өөрчлөлт хувьсал, дэвшлийн асуудлыг бүрэн тусгасан бөгөөд Монгол улсын хөгжлийн өнөөгийн шатан дахь гадаад бодлогын чиглэл, хандлагыг нэгтгэн тодотгожээ.

бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах; 14.2.-т АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх; түүнчлэн Монгол Улсын гадаад орчны өөрчлөлт, үндэсний аюулгүй байдлын шинэ асуудлууд, гуравдагч хөршийн бодлогыг тусгаснаас гадна Монгол улс дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдэхэд оролцох, гадаадад буй монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудлууд, гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах⁵ бодлогыг тусгаснаараа онцлогтой юм. Монгол улс энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт гадаад бодлогыг хэрэгжүүлж байгаа ба үүнд хөрш орнуудын маань хамтын ажиллагаа, дэмжлэгийг чухал гэж үздэг. Цаашид стратегийн түншлэлийн түвшинд хүрсэн харилцаагаа харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан, улам бататгаж, найрамдалт сайн хөршийн харилцаагаа зузаатгаж чадна гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Түншлэл хамтын ажиллагааны үзэл санаа

1994 оны 6 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Гадаад бодлогын үзэл баримтлалыг манай судлаач, эрдэмтэд “шилжилтийн эхэн үеийн гадаад бодлого, үйл ажиллагааны туршлагаар нотлогдсон практикт суурилахын хамт орчин үеийн олон улсын харилцааны чиг хандлагыг Монголын хөрсөнд тусгасан” чухал баримт бичиг болсон гэж дүгнэж үздэгтэй санал нэг байна. Харин Монгол улсын хувьсан өөрчлөгдсөн гадаад харилцааны шинэ орчин, түүний өөрчлөлт, бодит хэрэгцээтэй уялдуулан уг баримт бичгийг Монгол улсын Их Хурал 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр шинэчилсэн бөгөөд Монгол улс дээрх үзэл баримтлалыг үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл болгон ажиллаж байна.

“Гуравдагч хөрш”, “түни”, “түнишлэл” хэмээх нэр томъёо нь 1990-ээд оны эхнээс олон улсын харилцааны хэллэгт бодлогын

5. Д.Баярхүү. Монгол улсын Гадаад бодлогын анхны үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материал. УБ.,2014, тал 56-58.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН СОРИЛТУУД

шинжтэй, шинэ агуулга, хэлбэртэйгээр баттай орж ирэв. Тухайн улстай хөгжүүлж буй хоёр талын харилцааны агуулга, ач холбогдол, даацаа нь хамааруулж бид өнөөдөр дараах дөрвөн эрэмбээр түншлэлийн харилцаагаа ялгаж, эрэмбэлж байна. Стратегийн түншлэлийн харилцаа⁶ - Strategic partnership (ОХУ, БНХАУ, Япон), Иж бүрэн түншлэлийн харилцаа⁷ - Comprehensive partnership (БНСУ, Энэтхэг, АНУ, ХБНГУ, Турк), Өргөн хүрээтэй түншлэлийн харилцаа⁸ - Expanded partnership (Канад, Австрали, Казакстан), Сайн хөрш, найрамдал хамтын ажиллагааны түншлэлийн харилцаа - Good neighborliness, friendship and cooperation зэрэг эдгээр нэр томъёо нь олон улсын харилцааны баримт бичгүүд, өрнө дорнын эрдэмтэн судлаачдын бүтээлд өргөн хэрэглэгдэж, тайлбарлагдсаар байна.

Стратегийн түншлэлийн харилцааг ОХУ-тай 2006 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр гаргасан “Москвагийн

6. Стратегийн түншлэлийн харилцаа - Дээр дурдсанчлан түншлэлийн харилцааны хамгийн өндөр түвшин буюу Стратегийн түншлэлийн харилцааг Монгол улс ОХУ-тай 2009 оноос, БНХАУ-тай 2011 оноос, Японтой 2010 оноос хойш өргөжүүлэн хөгжүүлж байна. Ингэхдээ Стратегийн түншлэлийн харилцаанд тавигдах дараах суурь нөхцөлийг иш үндэс болгож байгаа билээ. Үүнд: Хоёр улсын хоорондын харилцааны хамгийн өндөр түвшнийг илэрхийлнэ. Урт хугацааны тогтвортой харилцаа байна. Улс төрийн итгэмжилсэн харилцааг тогтоож, өндөр дээд хэмжээний айлчлалын давтамжийг ойртуулна. Олон улсын болон бүс нутгийн томоохон асуудлаар бодлогын зохицуулалт, хамтран ажиллах механизм шаардах харилцаа, хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, нэмэгдүүлэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах зэргээр эдийн засаг, худалдааны урт хугацааны тогтвортой харилцаа, харилцан хамааралтай болно. Батлан хамгаалах болон цэргийн салбарт бие биендээ техникийн туслалцаа үзүүлэх, цэргийн мэргэжилтэн бэлтгэхэд туслалцаа зэргээр хамтран ажиллана. Соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарын харилцаа, хамтын ажиллагаа гүнзгийрнэ. Гамшигтай тэмцэх, гамшигийн хор хохирлыг арилгах талаар бие биендээ туслана. НҮБ-ын болон олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд хамтран оролцоно. Түүх, хэл, соёл, уламжлалын уг холбоог харгалзана гэсэн суурь нөхцөлүүдийг хангана.

7. Түншлэлийн харилцааны дараагийн түвшинд буюу Иж бүрэн түншлэлийн харилцааг Монгол улс АНУ-тай 2004 оноос, Турктай 2005 оноос, ХБНГУ-тай 2008 оноос, Энэтхэгтэй 2009 оноос, БНСУ-тай 2011 оноос хойш тус тус хөгжүүлж байна. Ингэхдээ Иж бүрэн түншлэлийн харилцаанд тавигдах дараах суурь нөхцөлийг гол иш үндэс болгож байна. Үүнд: Улс төрийн харилцаа өндөр, дээд түвшинд хүрсэн, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулж ажиллана. Хөрөнгө оруулалтыг харилцан дэмжинэ. Боловсрол, шинжлэх ухаан, технологи, соёл, эрүүл мэнд зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарт идэвхтэй хамтран ажиллана. Мэргэжилтэн бэлтгэхэд харилцан туслана. Батлан хамгаалах салбарт мэдээлэл, туршлага солилцох, мэргэжилтэн бэлтгэх зэргээр хамтран ажиллана. Хоёр улсын харилцан итгэлцлийг бэхжүүлэхийг эрмэлзэнэ. Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын зэрэг бүхий л салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлж буй учир “иж бүрэн түншлэл” хэмээн нэрлэдэг.

8. Түншлэлийн харилцааны гуравдугаар түвшин буюу Өргөн хүрээтэй түншлэлийн харилцааг Монгол Улс Канадтай 2004 оноос, Австрали, Казакстантай 2007 оноос хойш тус тус өрнүүлж байна. Ингэхдээ Өргөн хүрээтэй түншлэлийн харилцаанд тавигдах дараах суурь нөхцөлийг иш үндэс болгож байна. Үүнд: Улс төрийн харилцаа өндөр, дээд түвшинд хүрсэн байна, эдийн засгийн тодорхой салбаруудад хамтын ажиллагаа хөгжүүлнэ, боловсрол, шинжлэх ухаан, соёл зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарт харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлж эхэлнэ, цаашид харилцаа, хамтын ажиллагааг өөр бусад салбарт хөгжүүлэхийг эрмэлзэнэ, өргөн хүрээтэй түншлэл нь улс төр, эдийн засаг, нийгмийн бүх салбарыг биш, харин харилцан сонирхсон хэд хэдэн салбарыг онцлон хамардгаараа иж бүрэн түншлэлээс ялгаатай, зэрэглэлийн хувьд түүнээс доогуур түвшний харилцаа юм.

тунхаглал”-аар, 2009 онд ОХУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр гаргасан “Хамтарсан тунхаглал”-аар, БНХАУ-тай 2011 онд Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалын үеэр гаргасан “Хамтарсан мэдэгдэл”-ээр, Японтой 2010 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр гаргасан “Хамтарсан мэдэгдэл”-ээр, харин иж бүрэн түншлэлийн харилцааг БНСУ-тай 2011 онд тус улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсад айлчилсан дүнгийн тухай “Хамтарсан мэдэгдэл”-ээр, иж бүрэн түншлэлийг БНЭУ-тай 2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр гаргасан “Хамтарсан Тунхаглал”-аар, Хамтын үнэт зүйлс болон стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан иж бүрэн түншлэлийг АНУ-тай 2004 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр гаргасан “Хамтарсан мэдэгдэл”-ээр, иж бүрэн түншлэлийн харилцааг ХБНГУ-тай 2008 онд тус улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр, Турктэй 2005 онд хоёр улсын Ерөнхий сайд нарын “Хамтарсан мэдэгдэл”-ээр, өргөн хүрээтэй түншлэлийг Канадтай 2004 онд Монгол Улсын Ерөнхийлөгч, Канадын Ерөнхий сайд нарын 2004 оны “Хамтарсан мэдэгдэл”-ээр, Австралитай 2007 онд хоёр улсын Гадаад хэргийн сайд нарын “Хамтарсан мэдэгдэл”-ээр, мөн Казахстантай 2007 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын дүнгээр гаргасан “Хамтарсан мэдэгдэл”-ээр тус тус баталгаажуулсан байна.⁹

Түншлэлийн харилцаа нь хамтын ажиллагааны ямар нэг хатуу тогтсон үзэл сурталд тулгуурладаггүй. Харин улс орнуудын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцох, тэгш эрхтэй, харилцан ашигтай, хөгжлийн нийтлэг эрх ашиг, сонирхлыг тэргүүн зэрэгт тавих, улс бүрийн ялгаатай соёл иргэншил, амьдралын ёс жаягийг ойлгон хүндэтгэх, зөвшлийн үндсэн дээр шийдвэр гаргана гэж үйл ажиллагаандаа баримтлах зарчмаа төлөв тодорхойлж байна. Тэгэхээр түншлэл нь гуравдагч хөршийн бодлогын хүрээнд “иж бүрэн” байж болно, “стратегийн” ч байж болно гэж үздэг.

9. Мөн гэнд.,

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН СОРИЛТУУД

Монгол улсын “Гуравдагч хөрш” хэмээх нэр томъёоны гарал үүсэл

Монгол орон ардчилал, зах зээлд хөл тавимагц төр засаг, улс төр, эдийн засаг, бизнес, хүмүүнлэгийн хүрээнд орон зайгаа тэлэх шаардлага зүй ёсоор урган гарсан. Хүйтэн дайн, өрнө дорнын сөргөлдөөн төгсгөл болж, олон улсын харилцаа шинэ агуулгаар хөгжих таатай орчин бүрдэв. Ийм нөхцөлд Монгол улс нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулах болжээ. Шинэ эрин цагийн Монгол улсын гадаад бодлогын гол чиглэл нь 1994 онд УИХ-аар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д тов тодорхой тусгагдсан байна.

Улс төр хийгээд гадаад бодлогын баримт бичгүүдэд гуравдагч хөрш гэдэг ойлголтыг хэрэглээд удаж байна. 1990 онд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жеймс Бэйкэр¹⁰ Монгол улсад албан ёсны айлчлалын үеэрээ АНУ Монгол улсын хувьд гуравдагч хөрш байж болох үзэл санааг анхлан гаргасан байдаг. 1990 оны 7 дугаар сарын 26-нд Жеймс Бэйкэр ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэнгтэй өргөтгөсөн хэлэлцээ хийх үеэрээ “БНМАУ хоёр хөрштэй. АНУ тэдний аль нэгтэй харилцахдаа танай харилцаанд сэв суулгахыг боддоггүй. Танай улс АНУ-ыг оролцуулж гурван том улстай сайн хөршийн харилцаатай байж болох юм”¹¹ гэж тодорхой тэмдэглэсэн байна.

“Гуравдагч хөрш” гэдгийг аливаа жижиг улсын газарзүйн байрлалтай нөхцөлдөж, хоёр их хүчний хооронд шахагдахад өмгөөлж хамгаалах гуравдагч хүчнийг эрэн хайсан дипломат бодлогоос үүдэн гарсан “цэрэг стратеги, геополитикийн холбогдол бүхий олон улсын харилцаа, улс төрийн шинжлэх ухааны ойлголт” хэмээн товчхон тодорхойлж болно.

10. US Secretary of State James A. Baker in a statement given in August 1990., See Alicia J.Campi, “Mongolia’s Foreign Policy Vision for Eurasia”, paper presented at a Jamestown Foundation Seminar, 10 November 2010.

11. James A.Baker. The politics of Diplomacy: Revolution, War and Peace. Boston., 1995, p.116.

Олон улсын харилцааны реалист онолын төлөөлөгчид (Hans Morgenthau¹², Glenn H. Snyder¹³, Kenneth Waltz¹⁴, John J. Mearsheimer¹⁵, Robert Gilpin, Barry Buzan) нь “олон улсын харилцааны үндсэн оролцон тоглогчид нь үндэстэн улсууд” гэж үзэж, эдгээр тоглогчид өөр өөрсдийн үндэсний эрх ашгийг дээдлэх (national interest), хүчний тэнцвэрийн (balance of power) тухай онол гаргасан бөгөөд энэ нь Вестфалийн систем (Westphalia, 1648) гэдгээс эх үүдэлтэй. АНУ-ын геополитикч, профессор Ханс Моргентхау гадаад бодлого, дипломат ажиллагааны үндсэн дөрвөн зорилтыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд: “Нэгд, Дипломат бодлого хүч чадавх, бололцоондоо тохируулан өөрийн зорилтыг тодорхойлох ёстой, хоёрт, дипломат бодлого нөгөө улсынхаа зорилтыг тодорхойлох ёстой, гуравт, дипломат бодлого хоёр улсын зорилт хоорондоо хэр авцалдаж байгаагаа тодруулах ёстой, дөрөвт, дипломат бодлого дээрхид тулгуурлан өөрийн зорилтыг хэрэгжүүлэх аргыг зөв сонгох ёстой”¹⁶ гэж бичжээ. Энэ нь Монгол улсын гуравдагч хөршийн бодлогын онол, үзэл баримтлалыг боловсруулахад судалгааны чухал аргазүйн ач холбогдолтой болж байна. Гуравдагч хөршийн бодлогын онолын үндэс нь хүчний тэнцвэр (balance of power) болон ашиг сонирхлын тэнцвэр (balance of interest) бөгөөд энэ үзэл санаа 1713 оны Утрехтийн (Treaty of Utrecht) энхийн гэрээнд анх тэмдэглэгдэн үлджээ. Гуравдагч хөршийн бодлого нь манай улсын төрийн бодлого хийгээд хоёр талт харилцаа, хамтын ажиллагааны эрхзүйн баримт бичигт тусгагдаж, баталгаажиж байгаагаас гадна, мөн дээрхийг хэрэгжүүлэх олон талт хамтын ажиллагааны байнгын механизм байгуулж хөгжүүлэх нь илүү үр дүнтэй юм.

12. Hans Morgenthau. Politics among Nations: The Struggle for Power and Peace. New York, Seventh Edition. 2006, pp.539-540

13. Glenn H. Snyder, “Alliance Theory: A Neutralist First Cut” in The Evolution of Theory in International Relations, ed. Robert L. Rothstein (Columbia: University of South Carolina Press, 1991), 90;

14. Kenneth N. Waltz, Theory of International Politics (University of California, Berkeley: McGraw-Hill Inc., 1979), 118.

15. John J. Mearsheimer, The Tragedy of Great Power Politics. Norton, 2001. p. 29.

16. Hans Morgenthau. Politics among Nations: The Struggle for Power and Peace. New York, Seventh Edition. 2006, pp.539-540

**XX зууны эхэн үеийн Монголын гадаад харилцааны түүхэн дэх
“гуравдагч хөрш”-ийн үзэл санаа**

“Туравдагч хөрш”-ийн бодлого нь ардчилсан Монголтой холбоотой шинэ “нэр томьёо” мэт боловч энэ нь Монгол улсын XX зууны түүхтэй шууд холбоотой үйл явцын үргэлжлэл болж ирсэн байдаг. XX зууны түүхээс харахад Монгол улсын гадаад орчны нөхцөл байдалд томоохон өөрчлөлт явагдаж, Монгол Улс харьцангуй бие даасан гадаад бодлого явуулах боломж бүрдэх тутамд гуравдагч улсуудтай холбоо тогтоохыг оролдсон байдаг. Монгол улс 1911 онд тусгаар тогтнолоо зарласнаар Манжийн эзэнт улсын бүрэлдэхүүнээс албан ёсоор гарч, олон улсын хуулийн этгээдийн хувьд de facto оршин тогтнох болжээ. 1912 оны Монгол - Оросын найрамдлын гэрээ, 1915 оны Хиагтын гурван улсын гэрээ, 1921 оны Монгол - ЗОУ-ын найрамдлын гэрээ, 1936 оны БНМАУ-ЗХУ-ын харилцан туслалцах протокол зэрэг олон улсын гэрээ хэлэлцээрт хуулийн этгээдийн хувьд оролцож иржээ. Монголын хууль ёсны Засгийн газар 1911, 1921 онд дэлхийн улс орнуудад ноот бичиг албан ёсоор илгээж, тусгаар тогтносон тухайгаа тодорхой мэдэгдэж байв.

1911 оны тусгаар тогтнолын сэргэлтийн дараа Монголын удирдагчид хоёр хөршөөсөө гадна “гуравдагч хөрш”-тэй харилцаа холбоо тогтоохыг нэн чухалчилж байжээ. 1912 оны XI сард Монгол улсын ГЯЯ-наас ноот бичиг үйлдэн Их Фа (Франц), Ин (Англи), Дэ (Герман), Мэй (АНУ), Билиш (Бельги), Рибин (Япон), Дан ма (Дани), Хэ лан (Голланд), Ау (Австри) зэрэг есөн улсын ГХЯ-нд илгээжээ. Түүнд: “Дурдсан улсын Засгийн газруудтай дипломат төлөөлөгчид солилцож, харилцан гэрээ байгуулж, худалдаа нэвтрүүлж, улсын найрамдлыг зузаатгамуй”¹⁷ гэсэн саналыг дэвшүүлж байв. Нэг сарын дараа VIII Богд хаанаас хичээнгүйлэн Их Фа, Ин, Дэ, Билиш, Хэлан зэрэг таван улсын эзэн хааны амгаланг эрж, үүрд сайнаар найрамдахыг хүссэн албан бичгийг илгээж байжээ. Үүнийгээ 1913 онд Ерөнхий сайд, Сайн ноён хан Т.Намнансүрэн Санкт-Петербургт айлчлахдаа болон 1914 онд ГЯЯ-наас Бээжин дэх Өрнөдийн орнуудын ЭСЯ-дад илгээсэн ноот бичигт дахин нотолжээ.

17. Монголын ард түмний 1911 оны Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхэтгэл. 1910-1914. УБ., 1982, тал 61.

Ерөнхий сайд Т.Намнансүрэн Петербург хотод байхдаа тус хотод суугаа Англи, Америк, Турк, Япон зэрэг 10-аад улсын элчин сайд нарт ноот бичиг илгээж, Монгол улс Хятадаас тусгаар тогтсоноо албан ёсоор мэдэгджээ. Гэвч тэдгээр орны элчин сайдтай уулзаж, холбоо тогтоох, улмаар Европын орнуудад зорчих зорилго Оросын талын байр сууринаас болж олигтой бүтээгүй юм. Харин Ерөнхий сайд Т.Намнансүрэн Орост байхдаа Богд хаанаас Япон улсын Эзэн хаанд илгээсэн захидлыг уламжлан хүргүүлэхийг Оросын Гадаад хэргийн сайдаас хүсэж гүйцэтгүүлсэн байна. Богд хаан уг захидалдаа Өвөр Монголыг Хятадын түрэмгийллээс хамгаалах, Ар, Өвөр Монголыг нэгтгэж, улс үндсийг бүрэн бүтэн болгоход туслахыг Японы эзэн хаанаас хүсчээ. Хэдийгээр Японы Засгийн газар уг захидлыг хүлээн авахаас татгалзсан ч, энэ нь Монгол улс улс үндсээ нэгтгэж, тусгаар тогтнолоо баталгаажуулахын тулд зөвхөн хөрш Орос улсад хандаад зогсоогүй, бусад нөлөө бүхий улстай харилцахыг оролдож, идэвхтэй дипломат бодлого явуулж байсны нэгэн нотолгоо мөн. Энэ бол бас өнөөгийн Гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон гуравдагч хөршийн бодлогын эх үндэс байсан гэж хэлж болох үндэслэлтэй юм.

1913 оны эхээр Дотоод яамны тэргүүн сайд, да лам Г.Цэрэнчимэд, Бүгд ерөнхийлөн захирах яамны дэд сайд, бинт чин ван Гончигсүрэн нар Токио орохоор мордож, Богд хааны захидал бичгийг Японы цог жавхлантай Эзэн хаанд биеэр хүргэх, утга нь Монголын улс төрийн нэгдлийг хангахад туслах, тусгаар тогтнолоо зөвшөөрүүлэх, худалдааны өргөн харилцаа тогтоох агуулгатай байв. Мөн үед Богд гэгээний Засгийн газрын дипломатын талаар олсон амжилтын чухал хэсэг нь Түвдтэй байгуулсан 1913 оны есөн зүйлт гэрээ бичиг юм. Их гүрнүүд олон улсын харилцааны хэрэг явдлыг ил, далд элдэв аргаар бүхэлд нь шийдвэрлэж байсан тухайн үед Олноо өргөгдсөн Богд хаант улсаас шашин соёл нэгтэй гуравдагч хөрштэй байгуулсан анхны эрхзүйн баримт бичиг¹⁸ байв.

Монголын Засгийн газар байгуулагдсан үеэсээ дэлхийн улс орнуудтай худалдаа эдийн засгийн харилцаа тогтоох, улмаар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх гадаад бодлогыг тууштай эрэлхийлж

18. Д.Уламбаяр, Монгол улсын гуравдагч хөршийн бодлого: онолын баримтлал, түүх, орчин үеийн зангилаа асуудалд., Монгол улсын үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ.,2014, тал 102.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН СОРИЛТУУД

иржээ. 1914 онд Герман, АНУ, Англи, Францын засгийн газарт худалдааны харилцаа тогтоох саналыг албан ёсоор тавьж байсан бол 1920-иод онд Герман улстай худалдаа, эдийн засаг, боловсрол шинжлэх ухааны салбарт идэвхтэй хамтран ажиллаж байлаа. Тухайн үед Герман, АНУ нь БНМАУ-ыг *ad hoc* хүлээн зөвшөөрсөн гэж үзэж болно. 1911 оноос 1930 он хүртэл Монголд англи, америк, герман, япон, хятад, орос, турк зэрэг олон орны худадаачид Монголын засгийн газрын зөвшөөрлөөр үйл ажиллагаа эрхэлж байв. Ийнхүү 1911 оноос *de facto* оршин тогтнох болсон Монгол улс Ялтын хэлэлцээрээр Гадаад Монголын статус квог хүлээн зөвшөөрч, 1946 онд хоёр хөрш нь түүний тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрснөөр 1946 оноос *de jure*¹⁹ оршин тогтнох болсон түүхтэй.

Дэлхийн II дайнд ЗХУ тэргүүтэй холбоотнууд ялалт байгуулж, олон орон фашизм, милитаризмын эрхшээлээс ангижран салж, өөр өөрсдийн хөгжлийн замыг сонгох нөхцөл бүрдсэн. Европ болон Ази тивд хэд хэдэн орон социализмын замаар замнаж, ЗХУ-тай нэг адил тогтолцоонд нэгдэхээ тунхагласан бөгөөд эл үндсэн дээр дэлхийн социалист систем гэж нэрлэгдэж байсан улс орнуудын холбоо бүрэлдэн бий болжээ. БНМАУ 1948-1956 онд БНАСАУ, Албани, БНХАУ, Польш, Болгар, Унгар, БНАГУ, Чехословак, Румын, БНСВУ, Югославтай дипломат харилцаа тогтоож, дипломат төлөөлөгчийн газруудаа харилцан байгуулж эхэлсэн. Мөн манай улсын удирдагчид эдгээр оронд, социалист орнуудын удирдагчид манай улсад харилцан айлчлал хийж, найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээ, хэлэлцээр байгуулж байв. Ингэснээр манай улсын гадаад харилцаа гол төлөв хөрш хоёр оронтойгоо харилцаж байсан явцуу хүрээнээс хальж, Ази, Европ

19. Хаант засгийг халж Бүгд найрамдах засаглал тогтоход олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх асуудалд маш нааштай хандаж, богино хугацаанд хүлээн зөвшөөрдөг. Улсыг хүлээн зөвшөөрөх 3 хэлбэр байдаг. Үүнд:

1. Де юри – (De jure) Албан ёсоор бүрэн хэмжээнд хүлээн зөвшөөрч, тухайн улстай дипломат ба консулын харилцаа тогтоож эдийн засаг, худалдаа, харилцаа холбоо бүх тал дээр харилцаа холбоо тогтоодог.
2. Де факто – (De facto) Бүрэн бус хүлээн зөвшөөрөх хэлбэр. Хоёр улсын хооронд консулын болон худалдаа эдийн засгийн харилцаа тогтооно. Энэхүү хүлээн зөвшөөрөлт нь тухайн улсад бүрэн итгэл хүлээлгэхгүй байгаагийн илрэл юм. Энэ нь тухайн улсыг цаашид бүрэн хэмжээнд хүлээн зөвшөөрөхийн эхлэл болдог.
3. Ад хок – (Ad hoc) Тухайн улсыг хүлээн зөвшөөрөх сонирхолгүй боловч тодорхой нэг асуудлыг шийдвэрлэхийн тулд түр зуурын албан ёсны харилцаанд орохыг хэлнэ. Тухайн асуудлаа шийдвэрлэсний дараа хүлээн зөвшөөрлөө цуцлах, эсвэл үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрөх асуудал гардаг.

цаашлаад Африк, Америк тивийн орнуудтай харилцаагаа өргөжүүлэх зам нээгдсэн юм.

Манай улс социалист орнуудын зэрэгцээ дэлхийн нөлөө бүхий улсуудтай дипломат харилцаа тогтоох, харилцаа, хамтын ажиллагаагаа өргөтгөх бодлого бас явуулж байв. Үүний үр дүнд 1955 онд Энэтхэг Улс, 1963 онд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, 1965 онд Франц улстай дипломат харилцаа тогтоожээ. Түүнчлэн Бирм, Балба, Индонез, Гвиней, Мали, Камбож, Куба зэрэг Ази, Африк, Латин Америкийн орнуудтай дипломат харилцаа тогтоож, тэдгээрээс зарим орны удирдагчид Монголд албан ёсны айлчлал хийж, манай орны бодит байдал, хөгжил дэвшилттэй танилцаж байв. Тухайн үеийн Монголын улс төрийн зүтгэлтнүүдийн баримталж байсан дээрх чиг шугам тодорхой амжилтад хүрснийг онцлон тэмдэглэвэл зохино.

“Гуравдагч хөрш”-ийн бодлогын хэрэгжилт

Хүйтэн дайн дууссаны дараах Монгол улсын гадаад харилцаанд буй болсон шинэ хүчин зүйл нь хоёр хөршөөс гадна АНУ, Япон, Өрнөд Европ зэрэг дэлхийн бодлогод шийдвэрлэх нөлөөтэй зонхилох орнууд, хандивлагчдын бүлэг, Европын Холбоо болон олон улсын байгууллагууд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болсон. Үүний уг сурвалж нь Монголд гарсан ардчилсан өөрчлөлт, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц байсан бөгөөд тэдгээр орнууд Монгол улсыг ардчилсан шинэ тогтолцоонд шилжихэд бүх талын дэмжлэг үзүүлж, нөгөө талд урд, хойд хоёр хөршид нь шилжилтийг амжилттай даван туулж буйг загвар болгон харуулах давхар зорилго ч агуулж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

1990 оноос эхлэн Монгол улс гуравдагч хөршүүдийг тууштай эрэлхийлж АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын ардчилсан, аж үйлдвэржсэн орнуудыг анхаарах болсон. Тэгвэл Хятад, Орос гэх уламжлалт харилцаатай улс орнуудтай харилцах харилцаанд нь тэнцвэртэй байдал хадгалагдаж чадаж байна уу? Монгол бол далайд гарцгүй, зөвхөн Орос, Хятад улстай хиллэдэг болохоор газар зүйн байрлал нь “Гуравдагч хөрш” -ийн бодлого хэрэгжүүлэхэд гол хүчин зүйл болдог. Тиймээс урьдын ёсоор ОХУ, БНХАУ-тай харилцахаас гадна БНСУ, Тайланд, Сингапур, Турк,

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН СОРИЛТУУД

Дани, Голланд, Финланд, Австри, Швед, Швейцарь гээд олон оронтой эдийн засгийн салбарт гүнзгий харилцааг тогтоож байна. АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш 2005 онд Монголд айлчилж, олон улсын терроризмын эсрэг хамтран тэмцэж байгаа монголчуудад талархлаа илэрхийлснээс гадна Монгол улсыг АНУ дэмжих болно гэж мэдэгдсэн.

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж, ардчилал, хүний эрх, эрх чөлөөг жинхэнэ ёсоор баталгаажуулах бодлого явуулж эхэлсэн нь Өрнөдийн орнууд Монгол улстай харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх гол түлхүүр болсон юм. Дараах хүчин зүйл нь Өрнөдийн орнуудын Монгол улс дахь бодит сонирхлыг илэрхийлж буй Монгол улсын геополитикийн байршил юм. Тухайлбал: ЕХ-ны Дэд Комиссар Ханс ван ден Брук анх удаа 1996 оны IX сард Монгол улсад айлчлах үеэрээ хэлэхдээ: “Монгол улс геополитикийн чухал байрлалтай тул Европын Холбоо, Монгол улстай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх сонирхолтой байдаг” гэж хэлжээ. 2004 онд ЕХ-ноос Монгол улсад Суурин төлөөлөгчөөр сууж байсан доктор Клаус Эберманн хэлэхдээ “Монгол улсын газарзүйн байрлал нь Европын Холбоог Солонгосын хойгтой холбож байгаа юм” гэсэн нь буй.

Гадаад харилцааны сайд асан Г.Занданшатар: “Гуравдагч хөрш”-ийн бодлогын эрхэм зорилго бол Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний эрх ашиг, аюулгүй байдал, хөгжил дэвшлийн өнөө, ирээдүй уламжлалт хүчин зүйлсийн зэрэгцээ хоёр хөршийн төдийгүй, дэлхийн өндөр хөгжилтэй улс гүрнүүдийн стратегийн сонирхол, харилцан нөлөөлөл, хамаарлаар давхар баталгаажиж байх нөхцөлийг бүрдүүлэхэд орших байгаа юм²⁰ хэмээн “ЕАБХАБ-2011 он - Монгол Улс” олон улсын бага хурлын үеэр цохон тэмдэглэжээ.

Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд Өрнө, Дорнын хөгжингүй, ардчилсан орнуудын Монгол дахь эдийн засгийн бодит сонирхлыг буй болгох чиг шугам тодорхой сорилтуудтай тулгарч байгааг тэмдэглэх ёстой. Сүүлийн үед Монголын ашигт малтмал, байгалийн баялгийн асар их нөөц бүх дэлхийн анхаарлыг татах боллоо. Барууны зарим судлаачдын үзэж байгаагаар Монголын 10 том орд газрын нийт үнэлгээ 2.75 триллион ам.доллар болж байна.

20. Oxford Business Group, 'A good neighbour: OBG talks to G. Zandanshatar, Minister for Foreign Affairs and Trade', The Report: Mongolia 2012: Country Profile. Retrieved 9 August 2013, from <http://www.oxfordbusinessgroup.com/news/good-neighbour-obg-talks-g-zandanshatar-minister-foreign-affairs-and-trade>.

Монгол улс геополитик, стратеги, эдийн засгийн олон нөхцлийн улмаас дэлхийн томоохон үндэстэн дамнасан корпорациудын (Англи-Австралийн “Rio Tinto Group”, Хятадын “Shenhua”, “Chalco”, Америкийн “Peabody Energy”, Японы “Itochu”, “Mitsu”, “Sumimoto”, “Marubeni” гэх мэт) анхаарлыг татсаар байна. Монгол улсын Өмнөговь аймагт орших Оюутолгойн алт зэсийн орд, Тавантолгойн нүүрсний орд нөөцөөрөө Азид төдийгүй, дэлхийд дээгүүр байранд бичигдэнэ. Тухайлбал Лондонд бүртгэлтэй АНУ-ын “Soko International PLC” компани Тамсагийн сав газарт газрын тосны хайгуул үнэлгээний ажил явуулахаар Монгол Улсын Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан ч тодорхой үр дүнд хүрсний дараа ашиглалтын лицензийг 2005 онд Хятадын төрийн өмчийн “Петро Чайна Дачин Тамсаг [Монгол]” компанид худалдсан. Цаашилбал Канадын Ванкувер хотноо бүртгэлтэй “Western Prospector Group Ltd”, мөн Торонто хотод бүртгэлтэй “Khan Resource Inc.” Торонто, Нью-Йоркт бүртгэлтэй “SouthGobi Resources Ltd” (толгой компани нь “Turquoise Hill Resources Ltd” буюу хуучнаар “Ivanhoe Mines Ltd”)–салбар компани болох British Virginia-д бүртгэлтэй “SouthGobi Sands LLC”, Лондон, Мельбурн хотноо бүртгэлтэй Англи-Австралийн үндэстэн дамнасан корпораци “Rio Tinto Group”-ын явуулж буй үйл ажиллагааг энд тэмдэглэх хэрэгтэй.

2009, 2010 онд, Монгол улс 1994 онд баталсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-ын хоёр чухал хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулсан нь, нэгд, Засгийн газрын байнгын хурлаар “Гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр”-ийг боловсруулан баталж байх, хоёрт, “Туравдагч хөрш”-ийн гадаад бодлогыг хуулийн хэлбэрээр улам эрчимжүүлэх явдал байв. Дээрх хоёрын аль аль нь Монгол улс ашигт малтмал байгалийн баялгаа ашиглах эдийн засгийн арга замаар гадаад улс орнуудтай харилцан ашигтай хамтран ажиллах харилцаа тогтоох, бүр тодруулбал “Туравдагч хөрш”-үүдтэй харилцаагаа хөгжүүлэх талаар онцлон тэмдэглэсэн байна. Монгол улс байгалийн ховор элементийн нөөц дээрээ тулгуурлан, олон улсын харилцаа хамтын ажиллагааны хүрээгээ улам тэлсээр байна. 2016 онд Японы ерөнхий сайд Шинзо Абэ, Энэтхэгийн ерөнхий сайд Наренда Моду, ХБНГУ-ын ерөнхий сайд Франк Вальтер Штайнмайер зэрэг төрийн өндөр

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН СОРИЛТУУД

дээд хэмжээний хүмүүс ар араасаа Монголд айлчлал хийж, тус улсын “гуравдагч хөрш”-ийн гадаад бодлогыг улам бүр тодотгож өгсөн.

ЕТГ-ын дарга, П.Цагаан “Монгол улсын гуравдахь хөршийн бодлого нь хоёр хөршийн эсрэг бодлого биш юм. Бидний хувьд гуравдахь хөрш нь АНУ төдийгүй Канад, Европ, Япон, Солонгос гээд дэлхийн бусад орнуудыг хамруулсан ойлголт юм. Хоёрдугаарт, манай Ерөнхийлөгч 2014 онд Монгол, Хятад, Оросын гурвалсан уулзалт, хамтын ажиллагааны механизм бий болгох талаар санаачилга гаргасан бөгөөд үүнийг хөрш хоёр орны маань Ерөнхийлөгч нар дэмжиж хүлээн авсан. Хятад дахь хэлэлцээрийн үеэр манай Ерөнхийлөгч Улаанбаатарт гурван орны тэгш оролцоотой төсөл хэрэгжүүлэх судалгааны төв байгуулах санал гаргасан. Өөрөөр хэлбэл, том хэмжээний дэд бүтэц, эрчим хүч, төмөр зам, байгалийн хий, зам тээврийн гурван улсыг холбосон төсөл хөтөлбөрүүд боловсруулах замаар хамтарч ажиллах суурийг ийн тавих санал тавьсан. Бид хоёр хөрштэйгөө сайн харилцаатай байж, бусад оронтой ч мөн харилцаа сайтай байхыг эрмэлздэг. Бидний хүсэл мөрөөдөл бол Монгол Улсыг дэлхийн олон үндэстэн янз бүрийн шашин, арьс өнгөөс үл хамааран зочилж, хөрөнгө оруулж, амьдарч, хамтран ажиллах сонирхолтой, энх амгалан, ардчилсан улс болгох явдал юм”²¹ хэмээн 2015 оны 11 дүгээр сарын 9-11-ний өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн БНХАУ-д хийсэн Төрийн айлчлалын үеэр Хятадын CCTV News - World Insight нэвтрүүлэгт өгсөн ярилцлагадаа дурджээ.

Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогын улс төр, геополитик, аюулгүй байдлын үүднээс “Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална” гэж 3.2.2.2-т заасан нь аль нэг орны хөрөнгө оруулалтыг хязгаарлах бус харин тэнцвэртэй байдлыг хадгалахын тулд бусад орны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарахыг хэлж буй юм. Эрчимтэй хөгжиж байгаа хоёр томоохон зах зээлийн дунд байрласан нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах нэг үндсэн нөхцөл болдог. Монголын стратегийн

21. <http://www.president.mn/content/11871>

бүртгэгдсэн 15 орд газар байна. Монгол улсад 1990-2011 онд нийт 9.83 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орсон бөгөөд түүний 53.4 хувь нь БНХАУ-ын хөрөнгө оруулалт байна.²² Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 93 хувь нь уул уурхай, худалдааны салбарт хийгджээ. Үүнээс БНХАУ-ын компаниуд 58.3 хувийг, Оросын хөрөнгө оруулагчид 3.51 хувийг, бусад гуравдагч хөрш орнуудын хэмжээ 8.8 хувиас хэтрэхгүй байна.

“Гуравдагч хөрш”-ийн бодлогын хэрэгжилтэд илүү нарийвчлан тодотгох асуудал бий юу гэвэл бий. Ерөнхий байдлаараа үүнийг тоймловол: нэгдүгээрт, тухайн улс субъекттэй тогтоох, харилцах харилцааны түвшнийг илэрхийлсэн нэр томъёог логик агуулгатай болгох хэрэгтэй. Өнөөдөр түншлэлийн олон хэлбэр буюу иж бүрэн түншлэл, өргөн хүрээтэй түншлэл, өргөтгөсөн түншлэл, хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан иж бүрэн түншлэл, харилцан нөхсөн хамтын ажиллагаа, хөгжлийн түншлэл, стратегийн түншлэл зэргийн хоорондын зааг ялгааг сайтар гарган, түншлэлийн асуудлаар нэгдсэн ойлголттой болох шаардлагатай байна. Хоёрдугаарт, “гуравдагч хөрш”-үүдээс чухам аль улстай нь ямар түвшинд, аль салбарт, ямар чиглэлээр харилцаа, хамтын ажиллагааг илүүтэй хөгжүүлэх талаар бодлогын боловсруулалтыг анхаарвал зохино. Энд ямар нэгэн дэс дугаар тогтоох тухай биш боловч үгүйдээ хэнээс нь эхлэх зэрэг асуудлыг ярих нь зүйтэй юм. Гуравдугаарт, үнэхээр “гуравдагч хөрш” гэж албан ёсоор зааж бичсэн, эсвэл нэрлэж байгаа улстай бодлогынхоо өргөн цар хэмжээнд эргэж буцалгүй харьцаж, хамтын ажиллагаагаа туйлбартай өргөжүүлэн хөгжүүлэх хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, Монгол улсын гадаад бодлого нэгдмэл байдалтай, залгамж чанартай байна гэдгийг төрийн бодлого, үйл ажиллагаандаа тууштай мөрдөх нь хамгаас чухал юм.

Орос, Хятадын байр суурь

ОХУ Монголдулстөр, эдийн засгийн тодорхой нөлөөгөө хадгалсаар байгаа ч цаашид ч тодорхой хугацаанд БНХАУ нь Монголын улс төр, эдийн засгийн хамгийн чухал түнш орон байх хандлага ажиглагдаж байна. Хятад өнөөгийн байдлаар далайд гарцгүй Монголын хувьд худалдаа, хөрөнгө оруулалтын хамгийн том түнш, Ази номхон далайн

22. Монгол улсын Их хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН СОРИЛТУУД

бүс нутаг руу гарах том үүд хаалга болж байна. Хятадын бүс нутаг болон дэлхий нийтийн хэмжээн дэх байр суурь, нөлөө бэхжихийн хэрээр түүний Монголд хандах хандлага нь Монголын олон улсын аюулгүй байдал, хөгжил дэвшилд шууд нөлөөлөх чухал гадаад хүчин зүйл болсоор байх болно.

Монгол улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын тухайд хоёр хөрш ямар байр суурьтай байна гэдэг анхаарал татсан сонирхолтой асуудал юм. Өмнөд, Умард хөршүүд тааламжгүй байр суурь албан ёсоор илэрхийлж байгаагүй ч, харин олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд болон олон улсын харилцаа, геополитик, стратеги судлаачид өөрсдийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлсээр иржээ. Ж.Бушийн айлчлалын үеэр Хятадын “Чин нян цанкао”²³ сонинд бичихдээ: “АНУ Монголын “стратегийн байр суурь”-ийг олж харжээ. Чухамдаа Монгол том орнуудтай “зай барина” гэж байгаа бол Америк яагаад тэр “зайнд нь шургаж” болохгүй гэж, Америк Монголтой харилцах харилцаагаа идэвхийлэн хөгжүүлэх гээд байгаа нь Ази тивийн эх газар дахь стратегийн ашиг хонжоо хайх гэснээс үүдэлтэй бөгөөд тэнд “ардчиллын тогтолцоог” өргөжүүлэхийг зорьж байгаа юм гэж Америкийн зарим стратегийн шинжээчид тэмдэглэж байна. Монгол бол 1 сая 560 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, Хятад, Орос хоёртой хэдэн мянган километр газраар хиллэдэг. Хятад улс хөгжин бадарч, Орос сэргэн өндийж, Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын төрх төлөв нарийн ээдрээтэй байгаа энэ нөхцөлд Монголын газар нутгийн стратегийн байрлал нь улам бүр чухал болж байна. Монгол улс өнгөрсөн зууны 90-ээд оноос нээлттэй бодлого явуулж, Өрнөдийн соёлын нөлөөг улам ихээр авч байгаа болохоор Америкт “Азийн ардчиллын үлгэр жишээ” болж харагдаж байна. Америк, Монголын харилцаа улам гүнзгийрч байгаа нь Хятад, Орос хоёр хоршин ажиллаж байгааг саатуулж, Ази дахь АНУ-ын байр суурийг бэхжүүлж, ардчиллын үнэ өртгийг улам бүр гадагш тархааж, нэг сумаар олон туулай буудаж болох юм гэгцгээж байна. Үүнээс гадна хүн амтай нь жишээд үзэхэд Монгол Иракт илгээсэн цэргийн тоогоороо гуравдугаар байранд орж байна. Энэ бол Ж.Буш Монголд айлчлах хамгийн ойлгомжтой учир шалтгааны нэг болсон юм. Тэрбээр Монголд хувь хүнийхээ хувьд талархлаа

23. 青年参考, 2005 年03月25日

илэрхийлэх гэж байгаа хэрэг. Ийм дипломатын санаа нь дотооддоо улс төрийн талаар уналтад ороод байгаа Ж.Бушийн хувьд авч ярихад маш чухал зүйл гэдэг нь эргэлзээгүй юм” гэсэн байна.

Хятадын “Дорнын өглөө сонин”²⁴ 2011 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн дугаарт “Монгол улс Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагад элсэх хүсэлт гаргаж, Хятад Оросыг алгасан “Азиас Европ руу” харайхаар эрмэлзэж байна. Хятад, Оросын хооронд хавчигдан орших Азийн нэгэн улс болох Монгол улс нь Америк, Япон, Солонгос зэрэг улс орон хийгээд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ), НАТО, Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон улсын байгууллагуудтай “гуравдагч хөрш”-ийн гэх гадаад бодлогоо идэвхтэй хэрэгжүүлэхийг эрмэлзэж байна” хэмээн бичжээ. Хятадын умард хөрш Монгол улс “гуравдагч хөрш”-ийн гадаад бодлогоо бодитоор идэвхтэй хэрэгжүүлж эхэлж байна. Монгол гэх энэ улс Хятад Орос хоёр улсын дунд орших Азийн улс бөгөөд Америк, Япон, Солонгос зэрэг улс орнуудаар зогсохгүй Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, ЕАБХАБ, НАТО, Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагыг ч “гуравдагч хөрш”-ийн гадаад бодлогын төвөө болгон, улмаар Хятад Орос хоёр их хөрштэйгөө харилцах харилгаагаа тэнцвэржүүлэх нэрийн дор олон талт гадаад бодлогоороо Хятад, Оросыг тогтоон барихаар хичээж байна. 10 дугаар сарын 28-нд Монгол улсын гадаад харилцааны яам ЕАБХАБ-д элсэх өргөдлөө албан ёсоор өгч, Монгол улсаас Вена дахь олон улсын байгууллагуудын дэргэд суугаа байнгын төлөөлөгч Ж.Энхсайхан “ЕАБХАБ-ыг Монгол улсын гуравдагч хөрш болно” хэмээн найдаж байгаагаа илэрхийлсэн. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага 9 дүгээр сард төлөөлөгчдөө томилж, энэ асуудлаар Монголын талтай хэлэлцэж, улмаар энэ оны 10 дугаар сард тус байгууллагын сайд нарын хурлаас албан ёсны хариу өгнө гэж мэдэгдлээ. “Монгол улс ЕАБХАБ-ын санаачлан хэрэгжүүлэхээр зорьж буй улс үндэстний тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн, халдашгүй дархан аюулгүй байдал, эдийн засгийн хөгжил, байгаль орчин хамгаалал, хүний эрх, эрх чөлөө зэргийг хадгалан хамгаалах үндсэн зорилтуудыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ

24. 中国东方早报2011年11月02日(蒙古申请加入欧安组织欲超越中俄“脱亚入欧”)

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН СОРИЛТУУД

тус байгууллагын гишүүн орон болох нь Монгол улс эдгээр зорилт, үнэт зүйлсийг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болно үзэж байна” гэж Ж.Энхсайхан уулзалтын үеэр дурдсан бөгөөд Монгол улс ЕАБХАБ-ыг өөрийн “гуравдагч хөрш” болгохыг хүсч байгааг илэрхийлсэн байдаг. АНУ-аар толгойлуулсан НАТО, ЕАБХАБ-аар халхавч хийн Дундад Азид хөл тавих гэж байна. Энэ нь яалт ч үгүй Хятадын олон жилийн найдвар болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагыг шахаанд оруулан хавчиж буй хэрэг²⁵ хэмээн тэмдэглэжээ.

Хятадын судлаачид Монгол улсыг худалдаа, эдийн засгийн талаар Хятад руу хэлбийсэн байдаг бол, хөрөнгө оруулалт, шинэ техник, технологийн салбарт Япон, Канад, улс төрийн талаар АНУ-ын талыг баримталсан, цэрэг, батлан хамгаалах салбарт ОХУ-ыг түшиглэсэн шинжтэй байдаг хэмээн судалгаандаа дурдах боллоо. АНУ, Япон, Энэтхэг улстай “гуравдагч хөрш”-ийн хүрээнд стратегийн болон иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоож байгаа нь Хятадыг гурван талаас нь бүслэн хаах бодлогын илрэл юм, АНУ-ыг “гуравдагч хөрш” хэмээн үзэх болсон монголчууд үүнийгээ “олон тулгуурт гадаад бодлого” гэхчлэн тэд бичиж байгаа нь анхаарал их татдаг. Оросууд ч Монгол дахь АНУ-ын нөлөө нэмэгдэж байгаад таатай хандахгүй байгаа нь судлаачдынх нь үзэл бодлоос ойлгомжтой харагддаг. Үүнийг Оросын дипломат А.Козыревын Өрнөд Европыг чиглэсэн бодлогын хор уршиг гэх бөгөөд энэхүү хоосон орон зайд АНУ байр сууриа бэхжүүлж, Монгол дахь анхаарлаа сулруулсны хар гайгаар стратегийн чухал уулын баяжуулах Орос-Монголын хамтарсан “Эрдэнэт” үйлдвэр болон “МонРосцветмет” нэгдлийн 51 хувь монголчуудын мэдэлд шилжчихсэн гэх мэтээр бичсэн байдаг. ОХУ-ын сүүлийн үеийн судлаачид Монгол улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогыг Өрнөдийн орнуудтай холбоотны харилцаа тогтоох бодлогын илрэл, Оросын эсрэг чиглэсэн бодлогын чиг хандлага²⁶ хэмээн бичих явдал заримдаа ажиглагдаж байна.

Оросын ШУА-ийн Дорно дахины судалгааны хүрээлэнгийн секторын эрхлэгч, др. В.В.Грайворонский “Монгол улс: эрчимтэй

25. http://report.searchchina.cn/view_33197.htm

26. Д.Уламбаяр, Монгол улсын гуравдагч хөршийн бодлого: онолын баримтлал, түүх, орчин үеийн зангилаа асуудалд., Монгол улсын үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ.,2014, тал 108.

хөгжлийн эерэг төлөв” хэмээх өгүүлэлдээ “Монголд гадны олон орнуудын (Хятад, АНУ, Япон, БНСУ, ЕХ-ны улсууд, Их Британи, Герман, Канад гэх мэт) ашиг сонирхол төвлөрч өрсөлдөөн хурц байгаа тул Монгол дахь байр сууриа цаашдаа сулруулж хэрхэвч болохгүй, тэгвэл Орос - Монгол - Хятад - Америк гэсэн дөрвөлжинд манай улс хүчгүй болно. Энэ дөрөв дээр Япон нэмэгдэж магадгүй байна. Тиймээс Монгол улстай 2009 онд байгуулсан стратегийн хамтын ажиллагааны гэрээнд заасан бүх салбарт хамтын ажиллагаагаа эрх тэгш байдал, харилцан ашигтай байх зарчим дээр тулгуурлан идэвхтэй хөгжүүлэх, өөрийн хүлээсэн үүргийг хатуу чанга, хурдан шуурхай биелүүлэх, Монголын нийгмийн бүх салбарт уламжлалт байр сууриа хадгалан үлдэхээс гадна шинэ байр суурьтай болох, хоёр талын стратегийн харилцааг шинэ шатанд хөгжүүлэх шаардлагатай байна” хэмээн бичжээ.

Монгол улсын олон тулгуурт гадаад бодлогын агуулга бол үндсэндээ нэг хоёр, эсвэл нэг хэсэг улсад бус; аль болох маш олон улс орон, олон улсын форум, эсвэл, байгууллагад түшиглэн нийтлэг үнэт зүйлс, олон улсын эрх зүйд тулгуурлан явуулах үйл ажиллагааг хэлж байгаа юм.

Зөвхөн 2013 онд дээд, өндөр түвшинд хэрэгжүүлсэн 35 айлчлал, арга хэмжээний үеэр нийт 63 баримт бичиг байгуулсан байна.²⁷ Европын Холбоотой “Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр”, АНУ-тай “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай хэлэлцээр”, Японтой “Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр”, Хятадтай “Стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр” байгуулсан гээд томхоньг нь нэрлэчихье. 2014 оны эхний хасаг жилд дээд, өндөр түвшний айлчлалын үеэр 9 баримт бичиг, Засгийн газар хоорондын хоёр талт 6 гэрээ, байгууллага хоорондын 18 гэрээ тус тус байгуулсан байна. Ер нь гадаад айлчлал хэрэгжихгүйгээр гадаад бодлого, гадаад харилцаа нөхцөлдөж явагддаггүй. Монгол Улсын гадаад аюулгүй байдлын орчинд сүүлийн 20 гаруй жилд бий болсон харьцангуй таатай нөхцөл, бололцоог боломжийн хэрээр бүрэн ашиглаж Монголд олон орны төр засгийн тэргүүнүүд айлчилж, манай удирдлагууд олон орноор

27. www.mfa.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН СОРИЛТУУД

айлчилж олон баримт бичигт гарын үсэг зурсан нь Монгол улс дэлхий нийтэд нээлттэй, идэвхтэй, прагматик, олон тулгуурт гадаад бодлого явуулж байгаа нь сүүлийн 26 жилийн манай улсын гадаад харилцааны түүхэн дэх том дэвшил юм. Олон улсын харилцаа хамтын ажиллагааны хүрээгээ улам тэлж, төрийн өндөр дээд хэмжээний хүмүүс ар араасаа Монголд айлчлал хийж байгаа нь тус улсын “гуравдагч хөрш”-ийн гадаад бодлогыг дээд шатанд гаргаж байна.

Мөн 2015 оны 9 дүгээр сард АНУ-ын Нью-Йорк хотноо болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганы ерөнхий санал шүүмжлэлд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж үг хэлэхдээ “Монгол Улс нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж ирсэн. Чухамдаа энэхүү бодлого, байр суурь нь Монгол Улсыг байнга төвийг сахисан улс болгон зарлах боломжийг бүрдүүлж байна”²⁸ гэж мэдэгдэв. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулсан Монгол Улс байнга төвийг сахих тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчийн Хүний эрх, хуулийн бодлогын зөвлөх Ч.Өнөрбаяр УИХ-д өргөн мэдүүлэв. Уг хуулийн төсөлтэй холбогдуулан Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалд өөрчлөлт оруулах талаар УИХ-ын тогтоолын төслийг хамтатган боловсруулсан байна.

Монгол Улс байнга төвийг сахисан байр суурьтай байна гэж мэдэгдсэн нь олон асуултыг дагуулсан бөгөөд БНХАУ-ын “Нэг бүс, нэг зам” санаачилга хэрэгжиж байгаатай холбоотойгоор БНХАУ болон Монгол хоорондын хамтын ажиллагаа өргөжин тэлж байна. Төвийг сахих байр суурийг алхам алхмаар авч хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь Монголын гадаад бодлогын залгамж чанарыг харуулж байна. 1990 оны дараа Монгол Улс гадаад бодлогоо өөрчилж, эвсэлд үл нэгдэх статустай болсноор, Монголын нутаг дэвсгэрээр гуравдагч орны цэрэг дамжин өнгөрөх болон байрлах боломжгүй болсон. Мөн цөмийн зэвсэггүй болох санал дэвшүүлж, НҮБ-ын Аюулгүйн зөвлөл үүнийг хүлээн зөвшөөрсөн. Гадаад харилцааны хувьд Монгол Улс ОХУ болон БНХАУ-тай хоёуланттай стратегийн иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоосон бөгөөд ингэснээр Монголын гадаад байдал тогтвортой байх юм.

28. www.president.mn

БНХАУ болон ОХУ-тай сайн харилцаатай байх уламжлал бидэнд бий бөгөөд төвийг сахих бодлого нь гуравдагч хөршийн бодлогыг хөгжүүлэхэд илүү өргөн хүрээтэй орон зай, тохиромжтой байдлыг бий болгоно. Цаашдаа хоёр болон жинхэнэ гуравдагч хөрштэйгөө стратегийн түншлэлээ улам бэхжүүлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Монгол улс гадаад харилцааны бодлогоо батламжлах явцад хоёр хөрштэйгөө бүхэлдээ тэнцвэртэй харьцах харилцааг нэн тэргүүнд чухалчилж үзсэн байдаг. “Тэнцвэртэй харилцах” бодлого гэдэг нь ОХУ, БНХАУ-тай улс төрийн адил тэнцүү бодлого баримтлах явдал биш бөгөөд харин тэдэнтэй харьцах эрх ашгийн харилцаанд дундын тэнцвэртэй байдлыг барих явдал юм. Монгол улс нь Орос, Хятад улсын аль нэгтэй нь эвсэн нэгдэхгүй ба дайсагнахгүй, хоёр улсын маргаанд оролцохгүй, “харилцан итгэлцлээ баталгаажуулан, хамтран ашигтай ажиллаж, бүх талаар хөгжих” бодлогыг тууштай явуулж байна. Энэхүү тэнцвэржүүлэх бодлогын арга механизм нь Монгол улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого болж байна.

Жижиг улс зөвхөн өөрөө санаачлагатай идэвхтэй тоглогч байснаар олон улсын тавцан дээр өөрийн аюулгүй байдлыг хангаж хамгаалах бөгөөд ингэж үндэсний эрх ашгаа гүйцэлдүүлэх юм. Үүнийг манай гадаад бодлогын 20-иод жилийн амжилт нотолно. Нөгөө талаас тодорхой амжилтандаа хэзээ ч назгайрч болохгүй, аюулгүй байдлын үүднээс гадаад бодлогод, ялангуяа, дипломат үйл ажиллагаанд хамгийн олон төрлийн арга хэлбэрийг, шинэ соргог оновчтой гарцыг хайсаар байх учиртай. Энэ хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Хэдийгээр хоёр хөрштэй харилцах харилцаа түүхэнд байхгүй таатай бөгөөд тэнцвэртэй байгаа хэдий ч энэ нь манай улсын бодлого байр сууринаас илүүтэй гадаад орчноос, хоёр хөршийн хоорондын харилцаа, тухайлбал стратегийн түншлэлийн хэлбэрээр илрэх харилцаанаас хамаарч байгааг тооцож, харилцаанд өөрчлөлт гарах, хүйтэрч харилцаа муудах, эсвэл хэт сайдах нөхцөлд баримтлах гадаад бодлогын урьдчилсан прогнозтой байх. Харилцааг хэт нэг талруу хазайхаас сэргийлсэн тоглолт явуулах, хэт сайдах нь хоёр хөршийн

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН СОРИЛТУУД

хавсарсан шахалтанд орох, хэт муудах нь аль нэгийг сонгож, эргэн нэг гүрний шууд нөлөөнд орох аюул заналыг дагуулж байдгийг санах.

Гуравдагч хөршийн бодлогыг цаашид үргэлжлүүлэх нь Монгол улсын аюулгүй байдалд эерэг нөлөөтэй боловч аль нэг улсыг тусгайлан цохож, түүнтэй нягт харилцаанд орох нь эргээд гуравдагчийн зүгээс үзүүлэх тодорхой шахалтад өртөх аюултайг ямагт санах. Гуравдагч хөршийн бодлогыг зөвхөн бүрэн эрхт улсаар хязгаарлалгүй зарим судлаачдын үзсэнчлэн олон улсын харилцааны шинэ тоглогчдын хэмжээнд хүлээн зөвшөөрч өргөтгөх.

Эдүгээ хоёр хөршийн хүчний тэнцвэр тогтвортой байгаа явдал Монгол улсын аюулгүй байдлын нэгэн баталгаа болохын сацуу Монгол улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого хэрэгжих нэн таатай нөхцөл болж, “гуравдагч хөрш”-үүдийн бодит сонирхлыг Монгол улсад бий болгох, тэдэнтэй худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимтэй хөгжүүлэх, түүнчлэн тэдний хөрөнгө оруулалтыг татах явдал нэн чухал байна. Монгол Улсын гадаад бодлого эдийн засгийн тодорхой салбарт хоёр болон “гуравдагч” хөршүүдийн ашиг сонирхлын тойргуудын огтлолцлыг тэнцвэртэйгээр бүрдүүлж чадаж байгаа эсэх, ер нь энэ огтлолцлын бодлогын аргачлалаа томъёолсон эсэх нь цаг үеийн тулгамдсан асуулт болоод байна.